



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН
САЙДЫН ТУШААЛ

2018 оны 08 сарын 06 өдөр

Дугаар А/492

Улаанбаатар хот

Сургалтын хөтөлбөр батлах тухай


Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Бага, дунд боловсролын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн 29 дүгээр тусгай сургуулийн бага боловсролын Бэлтгэл хөтөлбөрийг нэгдүгээр, Монгол хэлний сургалтын хөтөлбөрийг хоёрдугаар, Математикийн сургалтын хөтөлбөрийг гуравдугаар, Яриа бичгийн сургалтын хөтөлбөрийг дөрөвдүгээр, Биет зүйлийн сургалтын хөтөлбөрийг тавдугаар, Айзамт хөдөлгөөнт дасгалын сургалтын хөтөлбөрийг зургаадугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Бэлтгэл, Монгол хэл, Математик, Яриа бичиг, Биет зүйл, Айзамт хөдөлгөөнт дасгал сургалтын хөтөлбөрийг 2018-2019 оны хичээлийн жилээс эхлэн сургуулийн хэмжээнд хэрэгжүүлж ажиллахыг сонсголын бэрхшээлтэй хүүхдийн 29 дүгээр тусгай сургуулийн захирал /Б.Батсайхан/-д даалгасугай.

3. Сонсголын бэрхшээлтэй 29 дүгээр тусгай сургуулийн Бэлтгэл, Монгол хэл, Математик, Яриа бичиг, Биет зүйл, Айзамт хөдөлгөөнт дасгалын сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Ерөнхий боловсролын бодлогын газрын дарга /Т.Ням-Очир/, Боловсролын хүрээлэн /П.Лхагвасүрэн/-д тус тус үүрэг болгосугай.


САЙД



ЦОГЗОЛМАА

Боловсрол, соёл, шинжлэх ухааны газрын
сайдын 2015 оны 5 сард 06 дугуйн А/492
тоот тушаалын хавсралт

СОНСГОЛЫН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН 30 ДҮГЭЭР
ТУСГАЙ СУРГУУЛИЙН БАГА БОЛОВСРОЛЫН
"ЯРИА БИЧИГ" ХӨТӨЛБӨР



НЭГ. ҮНДЭСЛЭЛ, ХЭРЭГЦЭЭ

Монгол Улсын Боловсролын тухай хуульд "Монгол Улсын боловсролын зорилго нь иргэнийг оюун ухаан, ёс суртахуун, бие бялдрын зохих чадавхитай, хүмүүнлэг ёсыг дээдлэн сахидаг, бие даан сурах, ажиллах, амьдрах чадвартай болгон төлөвшүүлэхэд оршино" гэж, Бага, дунд боловсролын тухай хуульд "Ерөнхий боловсролын тусгай сургууль нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд сэргээн засах, чийрэгжүүлэх, бие даалгах үйлчилгээ үзүүлж, бага, суурь, бүрэн дунд боловсрол, мэргэжил эзэмшүүлэх сургалтын байгууллага мөн." гэж тус тус заасан.

ЮНЕСКО-гоос 2015 оны 5 сард Тогтвортой хөгжлийн 4 дүгээр зорилтын хүрээнд БНСУ-ын Инчеон хотод "Хүн бүрт хүртээмжтэй, тэгш, насан туршдаа суралцах, чанартай боловсрол" сэдэвт Дэлхийн боловсролын форумас Инчеоны тунхаглалыг гаргасан. Тус тунхаглалд 2030 он хүртэлх Дэлхийн боловсролын алсын харааг "Нэгдсэн зорилго, хүсэл эрмэлзэлтэй, хүн бүрт хүрсэн боловсролын хөтөлбөрийг боловсруулна." хэмээн тодорхойлсон байдаг зэрэг нь хөтөлбөр боловсруулах үндэслэл болно.

Хэл яриа нь хүн төрөлхтний харилцааны гол хэрэглүүр юм. Сонсголын бэрхшээлтэй хүүхэд нь сонсох чадвараа алдсаны улмаас үгийн утга холбоог ойлгохдоо хангалтгүй, хэл ярианы хөгжил зогсонги, орчинтойгоо харилцах чадвар сул сургуульд элсдэг. Сонсголын алдагдал нь танин мэдэхүйн болон хувь хүний хөгжлийг сааруулж байдаг тул сонсголын бэрхшээлтэй хүүхдийн хэл яриаг хөгжүүлэх, сонсголтой хүмүүстэй харилцаанд орох суурь болж өгдөг учраас "Яриа бичиг" хичээл орох хэрэгцээ шаардлага зүй ёсоор урган гарч байна.

Анги нийтийн яриа бичгийн хичээлээр сурагчдад авиаг зөв дуудуулах, хүрээлэн буй юмс үзэгдлийг нэрлэх, багшаас өөрт хандаж хэлсэн үг хэллэгийг ойлгох болон өөрийн санаа бодлыг зөв илэрхийлэх, харилцан ярианд сургах, үгийн нөөцийг нэмэгдүүлэх, үлдэгдэл сонсголыг хөгжүүлэх зэрэг сургалтын цогц үйл ажиллагааг системтэй эзэмшүүлдэг.

Сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хүүхэд үгийн утгыг ойлгох нүдлэн тогтоох нь ярих дадлын суурь болдог бөгөөд хурууны үсэг болон дохионы хэл, аман болон бичгийн хэлээр үгийг илэрхийлэх энгийн мэдлэг эзэмших болно. Сургалт нь хоёр талтай үйл явц учраас багш, сурагчийн идэвхтэй үйл ажиллагаа, оролцоо хамтын үйл ажиллагаанаас хамааралтай байна.

Багш сургалтад дараах зарчмыг баримтална.

- Сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй сурагчийн нийгэмших ялгаатай хэрэгцээ (сонсголгүй, сул сонсголтой, хэл ярианы бэрхшээлтэй)-г харгалзах